



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Ажил үүрэг хариуцуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 18¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18¹.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, авто тээврийн салбарын бодлого, төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийг зохицуулах, орон нутгийн авто тээврийн асуудал хариуцсан албад болон бусад байгууллагуудын уялдаа холбоог хангах, авто тээврийн стандарт, норм нормативын хэрэгжилтэд хяналт тавих, салбарын техник технологийг шинэчлэх зэрэг авто тээврийн салбарын бодлоготой холбоотой асуудлуудыг Дэд сайд Х.Ержанд хариуцуулсугай.

2. Тухайн цаг үеийн болон салбарын бусад асуудлаар, мөн дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу сайдаас тухай бүр эрх шилжүүлсэний дагуу ажил үүргийг хариуцан гүйцэтгэхийг Х.Ержанд даалгасугай.



А.ГАНСҮХ